

Gripoflex 500 pulveris
MĒROGS 1:1
160 x 400 mm



Хэрэглэх заавар: Хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл

GRIPOFLEX 500

Ууж хэрэглэх уусмал бэлтгэхэд зориулсан нунтаг

Парацетамол / Аскорбины хүчил / Фенирамин малеат

Уг эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө энэхүү зааварт багтсан мэдээллийг сайтар уншиж танилцана уу.

Ихэвчлэн эм хэрэглэхийн өмнө энд тусгагдсан зааврыг эмч, эм зүйч танд мэдээлсэн байх ёстой.

- Зааврыг дахин унших шаардлага гарах тул хадгална уу.
- Өөр илүү мэдээлэл авахыг хүсвэл эм зүйчээс лавлана уу.
- Хэрэв танд зааварт тусгагдаагүй гаж нөлөө илэрвэл эмч, эм зүйчид мэдэгдэнэ үү. (4-р хэсэгт багтсан)
- Хэрэв таны бие эм хэрэглэсний 3 хоногт сайжрахгүй бол эмчид заавал мэдэгдэнэ.

Зааварт:

1. Грипофлекс 500 гэж юу вэ, юунд хэрэглэх вэ.
2. Грипофлекс 500 хэрэглэхийн өмнө танд юу шаардагдах вэ.
3. Грипофлекс 500 хэрхэн хэрэглэх вэ.
4. Илэрч болох гаж нөлөө
5. Грипофлекс 500 хэрхэн хадгалах вэ.
6. Бусад мэдээлэл багтсан.



1. Грипофлекс 500 гэж юу вэ, юунд хэрэглэх вэ

Грипофлекс 500 нь өвдөлт намдаах (өвдөлт хөнгөвчлөх), халуун бууруулах үйлдэлтэй нийлмэл бэлдмэл юм. Найрлагандаа идэвхтэй 3 нэгдэл агуулна: парацетамол, аскорбины хүчил (витамин С), Фенирамин малеат / цаашид фенирамин гэх/. Грипофлекс 500 эмийг амьсгалын дээд замын үрэвсэл, ханиад томууны үеийн толгой өвдөх, бие шархирах, халуурах, хамар, синус битүүрэх, ринит (нус гоожих), найтаах зэрэг шинж тэмдгийг арилгах зорилгоор хэрэглэнэ.

2. Грипофлекс 500 хэрэглэхийн өмнө танд юу шаардагдах вэ

Дараах тохиолдолд Грипофлекс 500 хэрэглэхгүй

- Хэрэв та бэлдмэлийн найрлага дах идэвхтэй болон бусад нэгдэлд харшилтай бол (6-р хэсэгт буй);
- Хэрэв таны цусны даралт өндөр бол (артерийн гипертензи);
- Хэрэв та нүдний хаалттай өнцөгт даралт ихдэлттэй бол;
- Хэрэв таны элэг, бөөр, зүрх судас, бамбай булчирхай, уушги хүнд хэлбэрээр өвчилсөн бол (мөн гуурсан хоолойн багтраа);
- Хэрэв та ходоод дээрх гэдэсний шархлаатай бол;
- Хэрэв та нойр булчирхай, давсагны эмгэгтэй бол;
- Хэрэв та хүндрэлтэй шээдэг бол (түрүү булчирхайн томрол);
- Хэрэв та цусны эсүүдийн эмгэгтэй бол;
- Хэрэв та ховор тохиолдох удмын эмгэг болох глюкоз-6 фосфат дегидрогиназа дутагдалтай бол (цусны улаан эсийн эмгэг);
- Хэрэв та жирэмсэн, хөхүүл бол эмийг хэрэглэхийг хориглоно.

Энэ эмийг өндөр настан болон 15-с доош насны хүүхдэд хэрэглэхгүй.

Цусны бүлэгнэлт алдагдсан өвчтөнд эмийг хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

Грипофлекс 500 эмийг найрлага дах парацетамол, фенирамин, стероид бус үрэвслийн эсрэг эмүүд, төв мэдрэлийн системд нөлөөлөх (гипнотик, гурван цагирагт сэтгэл уналтын эсрэг бэлдмэл, танквизаторууд), даралт бууруулах бэлдмэлүүдтэй хамт хэрэглэхийг хориглоно.

Анхааруулга, сэрэмжлүүлэг

Грипофлекс 500 хэрэглэх үед дотор муухайрах, бөөлжих, хэвлийгээр өвдөх, хоолны дуршил буурах, тайван бус болох, толгой эргэх, чих шуугих, сонсгол муудах, бухимдал төрвөл эмийн хэрэглээг зогсоон яаралтай эмчид мэдэгдэнэ.

Дараах тохиолдолд Грипофлекс 500 хэрэглэхийн өмнө эмчид мэдэгдэн болгоомжлох ёстой:

- Хэрэв та элэг бөөрний эмгэгийн улмаас шаналж буй бол (хүнд хэлбэрт хэрэглэхийг хориглоно);
- Хэрэв та цус үүсэлтийн эмгэгтэй бол ;
- Хэрэв та 65-с дээш настай бол ;
- Хэрэв та согтууруулах ундаа хэрэглэдэг бол заавал мэдэгдэнэ.

Хэрэв 3-с дээш хоног таны халуурах, өвдөх шинж тэмдэг байсаар байх болон хоолой улайсан бол эмчид хандана уу.

Парацетамол удаан хугацаанд өндөр тунгаар хэрэглэснээр элэг, бөөр хордуулж болно. Тунг хэтрүүлэн хэрэглэж болохгүй!

Грипофлекс 500 эмийн харилцан нөлөө

Та өөр зорилгоор эмийн бэлдмэл хэрэглэж буй бол эмч, эм зүйчид мэдэгдэнэ үү.

Грипофлекс 500 эмийг найрлага дах парацетамол, фенилэфрин, стероид бус үрэвслийн эсрэг эмүүд, төв мэдрэлийн системд нөлөөлөх (гипнотик, гурван цагирагт сэтгэл уналтын эсрэг бэлдмэл, танквизаторууд), даралт бууруулах бэлдмэлүүдтэй хамт хэрэглэж болохгүй.



Дараах эмүүдээс аль нэгийг хэрэглэж буй бол эмч, эм зүйчид мэдэгдэнэ үү:

- Барбитуратууд, фенитоин, карбамазепин, рифамицин, элэгний микросомын фермент идэвхжүүлэгчид (парацетамолын элэг хордуулах эрсдэлийг нэмэгдүүлнэ);
- зидовудин (парацетамолтой хавсарсан хэрэглээ аль алины хоруу чанар ихсэн, гранулоцитын тоо, цусны цагаан эсийн тодорхой төрөл буурах шинж олон удаа ажиглагдсан гэж тэмдэглэгдсэн);
- пенициллин (аскорбины хүчил пенициллины шимэгдэлтийг ихэсгэнэ);
- гепарин, шууд бус антикоагулянтүүд (аскорбины хүчил гепарин, шууд бус антикоагулян-туудын үйлдэлд нөлөөлнө);
- салицилатууд (хамт хэрэглэхэд аскорбины хүчил шээсэнд талст үүсэх эрсдэлийг нэмэгдүүлнэ).

Грипофлекс 500, согтууруулах ундаа

Согтууруулах ундааны нөлөөллийг нэмэгдүүлэх тул аль болох хамт хэрэглэхээс зайлсхийнэ. Мөн согтууруулах ундаа нь парацетамолын гаж нөлөөг нэмэгдүүлэх, цочмог нойр булчирхайн үрэвсэл үүсгэнэ.

Жирэмсэн, хөхүүл үе

Энэ эмийг жирэмсэн, хөхүүл үед хэрэглэхийг хориглоно.

Жолоо барих, механизмтай ажиллах чадварт нөлөөлөх

Энэ эм нь нойр хүргэж, ядраадаг учир машин барьж байх үед хэрэглэхгүй байх нь зүйтэй.

Энэ эмийн найрлаганд аспартам, жаргах нарны шар өнгө FCF (E110) агуулагдана

Энэ эм аспартам (фенилаланин эх үүсвэр) агуулах тул фенилкетонуригтай хүмүүсийн хувьд хор хөнөөлтэй байж болох юм. Энэ эм жаргах нарны шар өнгө FCF (E110) агуулдаг тул харшил үүсгэж болзошгүй.

3. Грипофлекс 500 хэрэглэх арга

Эмийн хэрэглэх зааврыг анхааран эмч, эм зүйчийн зөвлөгөөний дагуу хэрэглэнэ. Итгэлгүй байвал эмч, эм зүйчээс лавлана.

Эмчилгээг өвчний шинж тэмдэг илэрсэн даруйд аль болох хурдан эхэлнэ.

Нэг багцыг аяга халуун усанд найруулж бүлээнээр ууна.

Насанд хүрэгчид, 15-с дээш насныханд

Өдөрт гурван удаа уух ба нэг өдөрт 4-с их удаа хэрэглэхгүй. Хоногийн дээд тунг 3 багц. Тогтоогдсон тунг хэтрүүлэхийг хориглоно.



Бөөрний эмгэгтэй өвчтөнд

Эмийн тунг 8-с багагүй цагийн зайтай ууна.

Ахмад настанд

Тунг тохируулах шаардлагагүй.

Грипофлекс 500 тунг хэтрүүлэн хэрэглэсэн бол

Парацетамолын тунг хэтэрвэл аюултай. Ноцтой үр дагавар бий болохоос сэргийлж нэн даруй эмнэлгийн тусламж авах шаардлагатай.

Шинж тэмдэг: дотор муухайрах, бөөлжих, өрц, хэвлийгээр өвдөх, хоолны дуршил буурах, толгой эргэх, чих шуугих (чихэнд байнга юм сонсогдох), сонсгол муудах (ялангуяа өндөр настанд), тайван бус болох шинж илэрнэ

Хэрэв та Грипофлекс 500 хэрэглэхээ мартсан бол

Мартсан тунг давхарлан уухыг хориглоно.

4. Илэрч болох гаж нөлөө

Бүх эмийн адил хүн бүрд биш ч гаж нөлөө үүсгэж болох юм.

Элбэг (100 хүнд 1-с их)

- ам хатах
- дотор муухайрах
- өрц орчим өвдөх
- суулгах

Ховор (1,000 хүнд 1-с их)

- өндөр настанд нойрмоглох, толгой өвдөх, сэргэлт буурах
- аккомодаци алдагдах (харааны чадвар буурах)
- зүрхний цохилт нэмэгдэх
- цусны даралт түр зуур нэмэгдэх (даралт ихсэх)
- тууралт, загатнаа, чонон хөрвөс, Квинкын хаван (нүүр, уруул, хэл, хоолой, биеийн аль нэг хэсэгт гэнэт хавагнах, амьсгалах болон залгилах хүндрэлтэй болох)
- шээхэд хүндрэл үүсэх

Маш ховор (10,000 хүнд 1-с их)

- цус багадаалт (улаан эсийн дутагдал)
- тромбозитопени (цусны ялтас эсийн тоо буурах)
- лейкопени (цагаан эсийн тоо цөөрөх)
- агранулоцитоз (цусны цагаан эсийн тодорхой төрөл, гранулоцитын тоо их хэмжээгээр буурах)
- метемоглобулинеми (цусны метемоглобулин гемоглобины хэлбэр, нөхөн төлжилт хэвийн бус болох)

Гаж нөлөөний тайлан

Хэрэв танд гаж нөлөө илэрвэл эмч, эм зүйчид хэлнэ. Зааварт тусгагдаагүй гаж нөлөө илэрч болно. Иймд та үндэсний гаж нөлөөний тайлангийн системд мэдээлнэ. Ингэснээр энэ эмийн аюулгүй байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөд тусална.

5. Грипофлекс 500 хэрхэн хадгалах вэ

Гэрлийн тусгалаас хамгаалан, 25 °C ихгүй хэмд хадгална.

Хүүхдээс хол хадгална.

Савлагаан дээр заагдсан хугацаа дууссан бэлдмэлийг хэрэглэхийг хориглоно. Хугацаа дуусах он, сарын эцсийн өдрийг тэмдэглэсэн байна.

Хэрэглээгүй эмийн бэлдмэлийг бохир ус, ахуйн хог хаягдлаар дамжуулан устгахгүй. Удаан хэрэглээгүй эмийг хэрхэн устгах талаар эм зүйчээс лавлана уу. Энэ нь байгаль орчныг хамгаалахад туслах болно.

6. Бусад мэдээлэл

Грипофлекс 500 найрлага

Багц бүрд	
Парацетамол (<i>Paracetamol</i>)	500 mg
Аскорбины хүчил (<i>Acidum ascorbicum</i>)	200 mg
Фенирамин малеат (<i>Pheniramine maleas</i>)	25 mg



Бусад найрлаганд аспартам, маннитол, улбар шар амт оруулагч, жаргах нарны шар өнгө FCF (E110).

Грипофлекс 500 савлагаа, ерөнхий шинж

Цагаан ягаан туяатай ягаан нунтаг.

Савлагааны материал (цаас/полиэтилен хальсан/полиэтилен хальсан), ба (цаас /полиэтилен хальсан /хөнгөн цагаан тугалган/этилен, акрилын хүчил) бүхий савлагаатай.

Багцын хэмжээ: 5 гр бүхий 5 ширхэг багцыг хэрэглэх зааврын хамт цаасан хайрцагт савласан.

Үйлдвэрлэгч, маркетингийн зөвшөөрөл эзэмшигч

JSC Olainfarm
 5 Rupnicu Street, Olaine, LV-2114, Latvia